



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/26

Алтрага

**Сонгон шалгаруулах үнэлгээний хороо  
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих "Байгаль орчныг хамгаалах" 7,000,000 (долоон сая) төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Мөнхбат  
(Бэлтэс 5 дугаар багийн Засаг дарга)  
Гишүүн: Д.Долгормаа  
(Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан мэргэжилтэн)  
Нарийн бичгийн дарга: Л.Чимэдцэрэн  
(Засаг даргын орлогч)

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих "Байгаль орчныг хамгаалах" ажлыг хууль журмын хүрээнд зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ОДСЭР

Document-Zahiramg

**6729010060**